

# НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Илч-Орд ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй  
тайлан

**Аудитын код:** НТАГ-2025/041/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он</p>	<p><b>НТАГ-ын дэд дарга: Ч.Болд</b> Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn <b>Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр</b> Утас: 11-315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn <b>Аудитын менежер: Я.Алтанцэцэг</b> Утас: 11-325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn <b>Солид Юнити Аудит ХХК-ийн захирал: Э.Мөнхтогтох</b> Утас: 99063227 Цахим хаяг: munkhtogtokh.e@solidunity.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/275  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ИЛЧ  
ОРД ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Д.ГАНТУЛГА ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багахангай дүүргийн Илч-Орд ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 37.8 сая төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/695 дугаар “Эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай” тушаалаар 12 нэр төрлийн 115.0 сая төгрөгийн хөрөнгийг Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүлээлгэн өгч, 13 нэр төрлийн 8.3 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

### Аудитын гол асуудал

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн үндсэн хөрөнгө, эздийн өмч, санхүүгийн хөрөнгө, өр, төлбөр зэрэг бүлэгт Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу өөрчлөлт, шинэчлэлтийг тусгаагүй байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 стратеги зорилго, 12 зорилтын хүрээнд 76 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 90.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

**2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	41,837,006.69	7,435,474.17
1.1.02	Дансны авлага	30,106,947.30	50,411,210.32
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	1,152,681.08	1,152,681.08
1.1.04	Бусад авлага	2,456,663.42	487,409.47
1.1.06	Бараа материал	49,705,702.53	86,871,067.21
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,331,432.71	646,657.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>127,590,433.73</b>	<b>147,004,499.25</b>
1.2.01	Үндсэн хөрөнгө	2,974,787,266.07	2,893,884,304.03
1.2.02	Биет бус хөрөнгө	214,237,933.27	213,579,600.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>3,189,025,199.34</b>	<b>3,107,463,904.03</b>
<b>1.3</b>	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>3,316,615,633.07</b>	<b>3,254,468,403.28</b>
2.1.1.01	Дансны өглөг	210,266.13	183,520.00
2.1.1.02	Цалингийн өглөг	190,605.00	-
2.1.1.03	Татварын өр	17,182,829.70	26,908,139.25
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	2,984,199.00	1,398,983.00
2.1.1.12	Хойшлогдсон орлого	-	17,180,880.00
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>20,567,899.83</b>	<b>45,671,522.25</b>
2.1.2.5	Хойшлогдсон орлого	-	119,911,162.10
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>119,911,162.10</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>20,567,899.83</b>	<b>165,582,684.35</b>
2.3.01	Өмч: - төрийн	60,738,200.00	60,738,200.00
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	795,767,499.30	862,331,962.30
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	210,609,600.00	210,609,600.00
<b>2.3.09</b>	<b>Хуримтлагдсан ашиг (алдагдал)</b>	<b>2,228,932,433.94</b>	<b>1,955,205,956.63</b>
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг (алдагдал)	-	(273,726,477.31)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг (алдагдал)	2,228,932,433.94	2,228,932,433.94
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>3,296,047,733.24</b>	<b>3,088,885,718.93</b>
<b>2.4</b>	<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>3,316,615,633.07</b>	<b>3,254,468,403.28</b>

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	1,464,707,648.49	1,839,620,065.02
02	Борлуулалтын өртөг	(1,692,716,976.19)	(1,795,059,410.79)
<b>03</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>(228,009,327.70)</b>	<b>44,560,654.23</b>
04	Хүүний орлого	130,608.91	442,525.31
05	Бусад орлого	217,355,851.99	34,920,868.00
06	Ерөнхий ба удирдлагын зардал	(274,666,234.91)	(324,844,822.32)
07	Бусад зардал	(16,100,000.00)	(28,761,450.00)
<b>08</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)</b>	<b>(301,289,101.71)</b>	<b>(273,682,224.78)</b>
09	Орлогын татварын зардал	(13,865.98)	(44,252.53)
10	Татварын дараах ашиг (алдагдал)	(301,302,967.69)	(273,726,477.31)
11	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
<b>12</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(301,302,967.69)</b>	<b>(273,726,477.31)</b>
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
13.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
13.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
13.3	Бусад олз (гарз)	-	-
<b>14</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(301,302,967.69)</b>	<b>(273,726,477.31)</b>

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
<b>01</b>	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,665,904,113.50</b>	<b>795,767,499.30</b>	<b>210,609,600.00</b>	<b>(1,074,930,511.87)</b>	<b>3,597,350,700.93</b>
02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	3,605,165,913.50	3,605,165,913.50
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(301,302,967.69)	(301,302,967.69)
06	Өмчид гарсан өөрчлөлт	(3,605,165,913.50)	-	-	-	(3,605,165,913.50)
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
<b>09</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>60,738,200.00</b>	<b>795,767,499.30</b>	<b>210,609,600.00</b>	<b>2,228,932,433.94</b>	<b>3,296,047,733.24</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(273,726,477.31)	(273,726,477.31)
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	66,564,463.00	-	-	66,564,463.00
<b>17</b>	<b>2024 оны 12-р сарын 31-р нээрх үлдэгдэл</b>	<b>60,738,200.00</b>	<b>862,331,962.30</b>	<b>210,609,600.00</b>	<b>1,955,205,956.63</b>	<b>3,088,885,718.93</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,781,378,240.48</b>	<b>2,042,729,086.08</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	660,921,753.52	634,097,217.50
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	138,659.79	454,245.25
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	32,068.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	941,400,000.00	1,367,206,600.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	178,917,827.17	40,938,955.33
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,761,448,096.84</b>	<b>2,062,725,018.60</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	692,336,073.28	860,513,469.64
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	198,313,787.09	233,299,745.12
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	181,384,517.00	230,671,650.30
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	180,606,693.82	238,512,899.16
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	361,083,944.00	355,564,742.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	129,943,771.65	124,391,293.96
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	370,335.00	395,685.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	17,408,975.00	19,375,533.42
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>19,930,143.64</b>	<b>(19,995,932.52)</b>
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(10,154,905.00)	(14,405,600.00)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(10,154,905.00)	(14,405,600.00)
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(10,154,905.00)</b>	<b>(14,405,600.00)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>9,775,238.64</b>	<b>(34,401,532.52)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>32,061,768.05</b>	<b>41,837,006.69</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>41,837,006.69</b>	<b>7,435,474.17</b>

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны	2024 оны		2024 оны	Хувь
		Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэмнэлт (хэтрэлт)	
1	Санхүүжилтийн орлого	855,818,181.80	1,179,278,727.27	1,242,915,090.92	(63,636,363.65)	(5.40)
2	Дулаан борлуулсны орлого	573,585,866.69	520,341,120.00	557,796,621.60	(37,455,501.60)	(7.20)
3	Хэрэглээний халуун усны орлого	35,303,600.00	20,958,156.00	38,908,352.50	(17,950,196.50)	(85.65)
4	Бусад орлого	217,486,460.90	36,000,000.00	35,363,393.31	636,606.69	1.77
<b>Нийт дүн</b>		<b>1,682,194,109.39</b>	<b>1,756,578,003.27</b>	<b>1,874,983,458.33</b>	<b>(118,405,455.06)</b>	<b>(6.74)</b>
1	Үндсэн болон нэмэгдэл цалин	760,797,915.04	952,520,000.00	928,080,843.21	24,439,156.79	2.57
2	ЭМНДШ-ийн зардал	111,638,774.58	137,162,800.00	128,565,539.48	8,597,260.52	6.27
3	Цахилгааны төлбөр	115,022,941.80	144,784,330.25	121,953,877.81	22,830,452.44	15.77
4	Түлш халаалтын зардал	291,006,751.91	422,106,300.00	273,431,763.64	148,674,536.36	35.22
5	Цэвэр бохир усны төлбөр	56,802,574.55	69,640,065.00	73,678,760.00	(4,038,695.00)	(5.80)
6	Тээврийн зардал	20,985,700.00	27,237,600.00	19,732,300.00	7,505,300.00	27.55
7	Шуудан холбооны зардал	2,990,808.13	2,422,800.00	2,504,240.38	(81,440.38)	(3.36)
8	Урсгал засвар	71,626,192.30	43,086,200.00	99,569,781.64	(56,483,581.64)	(131.09)
9	Шатахууны зардал	56,336,551.40	44,448,550.00	53,762,379.32	(9,313,829.32)	(20.95)
10	Хөдөлмөр хамгааллын зардал	73,650,324.93	71,075,000.00	29,543,796.06	41,531,203.94	58.43
11	Бичиг хэргийн зардал	4,661,886.31	3,351,300.00	5,193,346.29	(1,842,046.29)	(54.97)
12	Нэг удаагийн буцалтгүй тусламж	16,100,000.00	16,660,000.00	19,110,000.00	(2,450,000.00)	(14.71)
13	Элэгдлийн зардал	353,871,429.06	205,255,400.00	357,192,104.38	(151,936,704.38)	(74.02)
14	Үйлчилгээний хөлс	5,708,400.00	5,931,112.64	6,636,183.42	(705,070.78)	(11.89)
15	Газрын төлбөр	1,873,296.00	2,113,296.00	2,109,192.00	4,104.00	0.19
16	Авто машины даатгалын зардал	302,112.29	468,045.00	627,865.21	(159,820.21)	(34.15)

№	Үзүүлэлт	2023 оны	2024 оны		2024 оны	Хувь
		Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэмнэлт (хэтрэлт)	
17	Үл хөдлөх хөрөнгийн татвар	8,590,575.06	8,590,575.04	8,675,775.04	(85,200.00)	(0.99)
18	Авто тээврийн хэрэгслийн татвар	281,735.00	233,904.00	297,678.00	(63,774.00)	(27.27)
29	Усны албан татварын зардал	2,272,028.00	2,200,000.00	2,386,100.00	(186,100.00)	(8.46)
20	Зам ашигласны төлбөр	220,000.00	190,000.00	220,000.00	(30,000.00)	(15.79)
21	Агаарын бохирдлын төлбөр	26,400.00	28,500.00	26,400.00	2,100.00	7.37
22	Авто тээврийн хэрэгслийн оношилгооны төлбөр	253,000.00	253,000.00	160,000.00	93,000.00	36.76
23	Хог хураамж	777,205.00	569,000.00	1,016,700.00	(447,700.00)	(78.68)
24	Вагон таталт тавилтын зардал	3,492,100.00	4,526,300.00	3,580,900.00	945,400.00	20.89
25	Бусад зардал	24,194,509.74		10,610,157.23	(10,610,157.23)	100.00
<b>Нийт дүн</b>		<b>1,983,483,211.10</b>	<b>2,164,854,077.93</b>	<b>2,148,665,683.11</b>	<b>16,188,394.82</b>	<b>0.75</b>
1	Татварын өмнөх ашиг /алдагдал/	(301,289,101.71)	(408,276,074.66)	(273,682,224.78)	134,593,849.88	32.97
2	Татварын зардал	(13,865.98)	-	(44,252.53)	-	-
3	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	(301,302,967.69)	(408,276,074.66)	(273,726,477.31)	134,549,597.35	32.96
4	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	1.2	1.23	1.15	0.08	6.50
5	Авлага	33,716,291.80	33,716,100.00	52,051,300.87	(18,335,200.87)	(54.38)
6	Өглөг	20,567,899.83	20,567,800.00	166,053,138.84	(145,485,338.84)	(707.35)

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Багахангай дүүргийн Илч-Орд ОНӨААТҮГ нь “Бид танд үйлчилнэ” гэсэн эрхэм зорилго болон “Чанартай үйлчилнэ” зорилтын хүрээнд дулаан, халуун усыг технологийн дагуу үйлдвэрлэн түгээж иргэдийг хэрэглээний халуун усаар хангаж тохилог орчин бий болгоход үндсэн чиглэлээ болгон үйл ажиллагаа явуулж байна.

Дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах үйл ажиллагааны хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Дулаан үйлдвэрлэх аж ахуйн үйл ажиллагааг аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу осолгүй ажиллуулах;
- Дулаан түгээх үйл ажиллагааг аваар, сааталгүй явуулах;
- Стандартын шаардлагад нийцсэн дулаанаар хэрэглэгчдийг тасралтгүй, найдвартай хангах;
- Дулаан түгээх сүлжээний хамгаалалтын зурвасыг холбогдох байгууллагаар баталгаажуулан ажиллах;
- Хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хангах талаар ажил төлөвлөн зохион байгуулж ажиллах;
- Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн хэрэглэгчдийн өргөдөл гомдол, саналыг тухай бүр шийдвэрлэх;
- Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан, гамшиг эмзэг байдал, эрсдэлийг бууруулах чиглэлээр ажил зохион байгуулах;
- 5919:2008 стандартын дагуу хяналтын хэмжилт хийлгэж, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний дагуу холбогдох арга хэмжээг авсан байх.

#### 3.2 ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

Багахангай дүүргийн Илч-Орд ОНӨААТҮГ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын багц хуулиуд, Эрчим хүчний тухай хууль, Нийслэлийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2019 оны 32 дугаар тогтоол, Эрчим хүчний зохицуулах хорооноос гаргасан тогтоолууд болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн хуулийн нэмэлт өөрчлөлт.
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль.

Тус ОНӨААТҮГ нь дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтангүй, 2024 онд дүүргийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын газраас 2023 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2024 оны 9-р сарын 30-ны өдрийг дуустал хугацааны байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явц, төсөв санхүүгийн үйл ажиллагаа, хүний нөөц, худалдан авах ажиллагааг хамарсан хяналт, шалгалт хийсэн байна. Дотоод аудитаар шатахууны зарцуулалтад тооцоо нийлсэн акт үйлдэж, хяналт тавьдаггүй, жолооны хуудас бүрэн зөв бөглөөгүй болон ажилтан албан хаагчдад цалингийн урьдчилгааг хяналтгүй өгч их хэмжээний авлага, өглөг үүссэн асуудлуудыг үндэслэн “сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлт өгсөн байна.

Дүүргийн дотоод аудитын тайланд тодорхойлсон тухайн асуудлыг аудитын гүйцэтгэлийн үед хянаж үзэхэд ажилчдын цалингийн урьдчилгаа бүрэн төлөгдсөн, шатахууны зарцуулалтын баримтын бүрдэл дутуу болон түүний хяналттай холбоотой зөрчилд аудитаар албан шаардлага өгсөн.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ОНӨААТҮГ-ын захирлын 2017 оны А/09 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим бүлэг нь холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй тул шинэчлэн боловсруулах зөвлөмж өгсөн.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт**

Багахангай Илч-Орд ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 62,145.2 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан байна.

## Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	41,835.0	7,435.5	(34,399.5)
Авлага	33,716.3	52,051.3	18,335.0
Урьдчилж төлсөн зардал	2,331.4	646.6	(1,684.8)
Бараа материал	49,705.7	86,871.1	37,165.4
Үндсэн хөрөнгө	3,189,025.2	3,107,463.9	(81,561.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,316,613.6</b>	<b>3,254,468.4</b>	<b>(62,145.2)</b>
Өр төлбөр	20,567.9	165,582.7	145,014.8
Эздийн өмч	3,296,045.7	3,088,885.7	(207,160.0)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,316,613.6</b>	<b>3,254,468.4</b>	<b>(62,145.2)</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данснууд байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 7,435.5 мянган төгрөг болж 34,399.5 мянган төгрөгөөр буурсан нь үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай бараа материалыг худалдан авсантай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 52,051.3 мянган төгрөг болж 18,335.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны халаалт, халуун усны төлөгдөөгүй авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 37,165.4 мянган төгрөгөөр өссөн нь ажилчдад хөдөлмөр хамгааллын хувцас худалдан авсантай холбоотой байна. Бараа материалын үлдэгдэл нь үндсэн үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулахад шаардлагатай бараа материалын үлдэгдлээс бүрдэж байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй байгаа болон их хэмжээгээр худалдан авч нөөцөлсөн материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,107,463.9 мянган төгрөг болж 81,561.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 300,447.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шинээр орлогод авч, 382,008.9 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөрийн данс 145,014.8 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг хойшлогдсон орлогоор бүртгэсэнтэй холбоотой нэмэгдсэн.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар эздийн өмчийн дүн өмнөх оноос 207,160.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс үүссэн алдагдалтай холбоотой байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Багахангай дүүргийн Илч-Орд ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Багахангай дүүргийн Засаг даргын баталсан Илч орд ОНӨААТҮГ-ын 2024 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшний төлөвлөгөөгөөр 1,756,578.0 мянган төгрөгийн орлого олж, 2,164,854.0 мянган төгрөгийн зардал гаргаж, 408,276.0 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж, борлуулалтын нэг төгрөгт ноогдох зардал 1.23 төгрөг байхаар баталсан байна.

Гүйцэтгэлээр дулаан борлуулалтын орлого 557,796.6 мянган төгрөг, хэрэглээний халуун усны орлого 38,908.4 мянган төгрөг, дулааны алдагдлын татаас 1,242,915.1 мянган төгрөг, бусад орлого 35,363.4 мянган төгрөг, нийт 1,874,983.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, үйл ажиллагаанд 2,148,665.7 мянган төгрөгийг зарцуулан, 273,682.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,874,983.5 мянган төгрөг болж төлөвлөснөөс 118,405.5 мянган төгрөг буюу 6.7 хувиар давсан байна. Үүнд: Багануур ХК-ийн нүүрсний үнэ нэмэгдсэн, хэвийн үйл ажиллагааг хангахад зориулан нүүрс тээвэрлэх автомашины дугуй худалдан авахад төсвийн тодотголоор 70,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмж олгосон, дулаан, халуун усны хэрэглээ нэмэгдсэн зэрэг нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,148,665.7 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 16,188.4 мянган төгрөг буюу 0.8 хувиар зардлыг хэмнэсэн байна. Тайлант онд өвөлжилтийн бэлтгэлд иргэдэд борлуулсан нүүрсийг бусад зардлаар бүртгэж, хойд болон баруун жигүүрийн шугамд тус тус 2-3 удаагийн цоорол гэмтэл гарсантай холбоотой шатахуун, урсгал засварын зардал, цэвэр бохир усны зардал өссөн ч өвөл өнөтэй, харьцангуй дулаан цаг агаартай өвөлжсөнөөс цалин, нийгмийн даатгалын зардал, түлш халаалт, тээврийн зардал төлөвлөснөөс бага зарцуулагдаж хэмнэлттэй ажиллахад нөлөөлсөн байна.

Тайлант онд эдийн засгийн зорилтот түвшнийг төлөвлөсөн алдагдлаас 134,549.6 мянган төгрөгөөр бууруулж, алдагдлыг багасгаж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Багахангай дүүргийн Илч-Орд ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотойгоор НБББББ-г холбогдох стандарт, хууль, журмын шинэчлэлийг тусган боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөх, капиталжуулалт болон хөрөнгийн дахин үнэлгээний тайланд тусгасан ашиглах жилийг санхүүгийн программд шалган оруулж хөрөнгийн ашиглах жил, элэгдлийн тооцоололд тавих хяналтыг сайжруулах, ур чадварын нэмэгдлийг харгалзах шалгуур үзүүлэлтээр, ажлын үр дүнг үнэлэн, баримтаар баталгаажуулан олгох, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт болон нотлох бусад баримтын бүрдлийг хангах, хяналт тавьж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Солид Юнити Аудит ХХК-ийн аудитор Д.Бадамцэцэг, аудиторын туслах Э.Цэнддорж, Г.Золзаяа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын удирдлагын менежер Н.Тунгалаг, захирал Э.Мөнхтогтох, НТАГ-ын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, дэд дарга Ч.Болд нар тус тус хэрэгжүүлсэн.

Багахангай дүүргийн Илч-Орд ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 15 дугаар албан бичгээр Солид Юнити Аудит ХХК-д ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт орлогын 1,682,194.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 25,232.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь батлагдсан зорилтот түвшний дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалт, хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхэд горим сорил хэрэгжүүлэн шалгахад дэд дарга, орлогч дарга, зөвлөх албан тушаалын орон тоогүй, албан томилолтын зардал гараагүй, гар утасны төлбөр болон хэвлэлийн зардал гаргаагүй, бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй, хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгоогүй байна.

Цэвэр бохир усны зардлыг өмнөх онтой харьцуулахад 16,876.2 мянган төгрөгөөр буюу 29.7 хувиар өссөн байна. Энэ нь дулаан, хэрэглээний халуун усны шугамд гарсан цоорол гэмтэл болон цэвэр, бохир усны төлбөр 2024 оны 11 дүгээр сараас нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2024 онд нийт 2,307,223.2 мянган төгрөгийн 104 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 743,603.1 мянган төгрөгийн 29 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.

Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 551,988.8 мянган төгрөгийн орлогын 11 гүйлгээ, 191,614.3 мянган төгрөгийн зарлагын 18 гүйлгээг тус тус хугацаа хоцроон байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад таван мянга төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулах зарим мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй зөрчлийг зогсоож, дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянахад илүү цагийн нэмэгдлийг дундаж цалин хөлсийг үндэслэн тооцоогүй 1,871.4 мянган төгрөгөөр зөрүүтэй олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 109.1-д “Илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 тоот тушаалын хавсралт Дундаж цалин хөлс тодорхойлох журмын 2.2-т “Илүү цаг, шөнийн цаг, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтны нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо тухайн ажилтны сүүлийн 3 сарын цалин хөлсөөр тооцно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү цагийн нэмэгдлийг дундаж цалин хөлсийг үндэслэн тооцох, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн зарим заалт, илүү цагийн нэмэгдлийн тооцоолол нь Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох журмын шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хамруулж илрүүлсэн алдаа, зөрчлийг асуудлын бүртгэлээр танилцуулж 8,689.4 мянган төгрөгийн 3 залруулга, 252,721.4 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 1,012,067.4 мянган төгрөгийн 3 албан шаардлагыг хүргүүлсэн.

Хэрэгжилтийг шалгахад 1,262.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 743,603.1 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг биелүүлээгүй байна. Тухайн асуудлуудыг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 зөвлөмж, 1 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	302,970.3	1	302,970.3	100.0
Зөвлөмж	4	25,295.8	4	25,295.8	100.0
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>328,266.1</b>	<b>5</b>	<b>328,266.1</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авлагын насжилтыг тодорхойлон эргэн төлөгдөхгүй байх эрсдэлтэй авлагын үлдэгдэл байгаа эсэхийг анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 271,323.1 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Дахин үнэлсэн 100,568.5 мянган төгрөгийн хөрөнгийн өмнөх өртөг, элэгдлийг хааж бүртгээгүй, дүнг дутуу бүртгэсэн, балансаас балансад шилжин ирсэн хөрөнгийн 24,816.8 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг бүртгээгүй;
- Үнэ төлбөргүй хүлээн авсан 142,267.0 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материалыг хойшлуулсан орлого болон бусад орлогоор бүртгэлгүй, хуримтлагдсан ашигт бүртгэсэн;
- Тайлант онд 2,855.4 мянган төгрөгийн орлогыг ангилал зөрүүлэн, 486.2 мянган төгрөгийн орлогыг дутуу бүртгэсэн;
- Зардлыг 329.3 мянган төгрөгийг ангилал зөрүүлэн бүртгэсэн.

Аудитаар нийт 36,183.8 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 262.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 26,067.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 9,853.3 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 36,183.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 10,950.9 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Тэмцээн уралдааны шагналаас 262.9 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 19.1.1-д “урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал болон тэдгээртэй адилтгах бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогын дүнгээр”, 21.2.2-т “энэ хуулийн 19.1.1-д заасан орлогын дүнд 5 хувиар”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-т “үнэн зөв байх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн дагуу суутгаагүй 262.9 мянган төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

### 5.2 Албан шаардлага

Тайлант онд 26,067.6 мянган төгрөгийн шатахууныг дараа тооцоогоор бүртгээгүй, зарцуулалтыг нотлох тооцооны хуудас, тооцоо бодсон зарцуулалтын баримтууд дутуу, зарцуулалтад хяналт тавьж баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1.3-т “анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шатахууныг дараа тооцоогоор бүртгээгүй, зарцуулалтыг нотлох баримтууд хангалтгүй, хяналт тавьдаггүй зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1.НБББББ-тэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын мөрдөж буй НБББББ-ийн зарим бүлэг болох үндсэн хөрөнгө, эздийн өмч, санхүүгийн хөрөнгө, өр төлбөр зэргийг СТОУС болон бусад дүрэм журмын дагуу шинэчлэн боловсруулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: НБББББ-ийг холбогдох стандарт, хууль, журмын дагуу шинэчлэлийг тусган боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

#### 2. Нэмэгдэл цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Ажилчдад 896.4 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг олгохдоо шалгуур үзүүлэлтээр ажлын үр дүнг үнэлж дүгнээгүй олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т “үнэн зөв” байх болон Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалын хавсралт төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 2-д “Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд тогтмол сайн гүйцэтгэдэг буюу бусдаас илүү идэвх санаачилга, өндөр үр дүнтэй ажиллаж байгаа түгээмэл мэргэжлийн албан хаагчдад дараах үндсэн шалгуур үзүүлэлтийг харгалзан ур чадварын нэмэгдэл олгоно” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт болон иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ур чадварын нэмэгдлийг харгалзах шалгуур үзүүлэлтээр, ажлын үр дүнг үнэлэн, баримтаар баталгаажуулан олгох, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгөв.

### 3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмнөх тайлант жилүүдэд дахин үнэлсэн болон капиталжуулсан хөрөнгийн ашиглах жилийг программд өөрчлөөгүйгээс хөрөнгийн бүртгэл болон хуримтлагдсан элэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т "үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид капиталжуулалт болон хөрөнгийн дахин үнэлгээний тайланд тусгасан ашиглах жилийг санхүүгийн программд тулган оруулж хөрөнгийн ашиглах жил, элэгдлийн тооцоололд тавих хяналтыг сайжруулах зөвлөмж өгөв.

### 4. Бусад орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нүүрс борлуулалтын орлогыг түүвэрлэн шалгахад гэрээ байгуулж, зарлагын баримт үйлдээгүй 8,956.9 мянган төгрөгийн борлуулалт бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээ түүнийг нотлох анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж, үнэн зөв нотлох баримтад үндэслэн бүртгэл хөтлөх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дахин үнэлсэн хөрөнгийн өмнөх өртөг, элэгдлийг хаагаагүй, балансаас балансд шилжин ирсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг бүртгээгүй.	1	125,385.2	-	-	1	125,385.2	1	125,385.2	-	-	-	-
Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалыг хойшлуулсан орлого болон бусад орлогоор бүртгээгүй.	1	142,267.0	-	-	1	142,267.0	1	142,267.0	-	-	-	-
Орлогыг дутуу болон ангилал зөрүүлэн бүртгэсэн.	1	3,341.6	-	-	1	3,341.6	1	3,341.6	-	-	-	-
Зардлыг ангилал зөрүүлэн бүртгэсэн	1	329.3	-	-	1	329.3	1	329.3	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>271,323.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>271,323.1</b>	<b>4</b>	<b>271,323.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
НБББББ-ийн зарим бүлгийг СТОУС, бусад дүрэм журмын дагуу шинэчлэгдээгүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Нүүрс борлуулалтын орлогыг гэрээгүй, зарлагын баримтгүй бүртгэсэн.	1	8,956.9	-	-	-	-	1	8,956.9	-	-	-	-
Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтээр ажлын үр дүнг үнэлж дүгнэлгүйгээр олгосон.	1	896.4	-	-	-	-	1	896.4	-	-	-	-
Шатахууныг дараа тооцоогоор бүртгэдэггүй, зарцуулалтын баримтууд дутуу, хяналт тавьдаггүй.	1	26,067.6	-	-	1	26,067.6	-	-	-	-	-	-
Шагналаас хувь хүний орлогын албан татвар суутгалгүй олгосон.	1	262.9	1	262.9	-	-	-	-	-	-	-	-
Өмнөх тайлант жилүүдэд капиталжуулсан, дахин үнэлсэн хөрөнгийн ашиглах жилийг программд өөрчлөөгүйгээс хуримтлагдсан элэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэн.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>36,183.8</b>	<b>1</b>	<b>262.9</b>	<b>1</b>	<b>26,067.6</b>	<b>4</b>	<b>9,853.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны цахим хуудаст 29 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	1	743,603.1	1	743,603.1	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>743,603.1</b>	<b>1</b>	<b>743,603.1</b>	<b>-</b>	<b>-</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Илүү цагийн нэмэгдлийг хуулийн дагуу дундаж цалин хөлсийг үндэслэн тооцдоггүй.	1	1,871.4	-	-	1	1,871.4
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,871.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>1,871.4</b>
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>745,474.5</b>	<b>1</b>	<b>743,603.1</b>	<b>1</b>	<b>1,871.4</b>